



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 31 өдөр

Дугаар А/455

Есөнбулаг

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Авто замын тухай хуулийн 28.1, 28.2 дахь заалт, Зам тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 49 дүгээр тушаалаар батлагдсан “Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад авах журам”-ын 4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн Солонго хорооллын дунд замын уулзвараас стадион хүртэл авто зам татах ажлын гүйцэтгэлийг хүлээн авч ашиглалтад оруулах үүрэг бүхий Комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	Л.Хаш-Эрдэнэ (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)
Гишүүд	Н.Алтанбагана (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн авто тээврийн хяналтын улсын байцаагч)
	Б.Батбилэг (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын хяналтын улсын байцаагч)
	Ц.Бат-Орших (Алтай хотын тохижилт үйлчилгээний газрын дарга)
	Ж.Билэгсайхан (Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн)
Нарийн бичгийн дарга:	Ж.Батдэлгэр (“Хайчийн нуруу” ХХК-ийн захирал, гүйцэтгэгч)

2. Орон нутгийн өмчид бий болсон хөрөнгийг хүлээж авсан акт, баримт бичгийг үндэслэн хөрөнгийг бүртгэж, хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг)-т, байгууламжийн урсгал засвар, үйл ажиллагааны зардлыг төсөвт тусгах, цаашдын ашиглалт, арчилгаа, хамгаалалтыг хариуцаж ажиллахыг Есөнбулаг сумын Засаг дарга (А.Алтанхуяг), ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, ашиглалтад хүлээн авахыг ажлын хэсэг (Л.Хаш-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ОРЛОГЧ

Г.ЧИНБАТ

